



ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.НОМИН
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/373
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0224\SAQ51.Docx

079518



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ,
БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

УАГ –ын Санхүүгийн Аудитын Газрын
Дарга: Ц.Наранчимэг
Утас: 263533

Аудитын менежер : Я.Самбууням
Утас: 260512

Аудитор: Ж.Болормаа

Аудитор : “Координат Аудит” ХХК
Гүйцэтгэх захирал - П.Баярмаа
Утас : 99193732

АУДИТЫН ТАЙЛАН

2016 оны Санхүүгийн тайлангийн аудит

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Монгол улсын

Үндэсний аудитын газар

Хаяг : Засгийн газрын IV байр,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу – 6,
Улаанбаатар – 46, Монгол улс

Вэб хуудас: www.mnao.pmis.gov.mn

Хэвлэсэн огноо :
2017 оны 2 –р сарын 20

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Материаллаг байдлын түвшин
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын дүгнэлт

АУДИТ ХИЙХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 болон 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” –ийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” –ийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын Стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга, илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС – тай нийцүүлж, материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын ажлыг 2016 оны 10 дугаар сарын 26 –ны өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 15 –ны өдрийн хооронд гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу "Координат Аудит" ХХК –ийн аудитын баг гүйцэтгэв.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 17 –ны өдөр "Координат Аудит" ХХК –д ирүүлсэн байна.

"Координат Аудит" ХХК жилийн эцсийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 17 –ны өдрөөс 2017 оны 2 дүгээр сарын 17–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 27–ний өдөр Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн удирдлагад гардуулна.

БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Усны тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Төсвийн тухай хууль”, “Нягтлан болох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд “Нягтлан болох бүртгэлийн тухай хууль” шинэчлэгдэн 2016 оны 1 сарын 1 – нээс эхлэн мөрдөгдөж эхэлсэн. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам” Сангийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 8 –ны өдрийн 131 дүгээр тушаалаар батлагдан, мөрдөгдөж эхэлсэн. Эдгээрээс бусад хууль, тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалалах төвийн эрхэм зорилгоо “байгаль орчны чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, бүх нийтэд экологийн боловсрол олгох замаар байгаль дэлхий, нутаг усаа хайрлах соёлыг төлөвшүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалалах төвийн захирал төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай, Монгол Улсын иргэний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага “Байгаль орчин, цэнгэг усны чиглэлээр сургалт, сурталчилгаа, судалгаа шинжилгээний ажил явуулах” гэсэн үндсэн үйл ажиллагааны чиглэлтэйгээр ажиллаж байна.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалалах төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ХЯНАЛТЫН СОРИЛ БОЛОН НАРИЙВЧИЛСАН ГОРИМ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалалах төвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 39 -г гүйцэтгэв.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалалах төвийн санхүүгийн үйл ажиллагаандаа “Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам” –с боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 оны санхүүгийн тайлант жил дуустал мөрдөж ажилласан байна.

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох групп” ХХК -ийн Акулус санхүүгийн програм, цалингийн Пэйрол программуудыг ашиглан санхүүгийн тайланг гаргасан байна.

Энэхүү программ болон компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс хяналтын сорилыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр гүйцэтгэсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” -ийн дотоод хяналтын үйл ажиллагааны уламжлалт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хийсэн сорилоор хэвийн гэж тогтоосон.

ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлыг төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.

2016 оны санхүүгийн тайлант жилд улсын төсвөөс 294.4 сая төгрөгийн урсгал зардлын, 135.6 сая төгрөгийн нэмэлт, нийт 430.1 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснөөс, үйл ажиллагааны зардалд 370.9 сая төгрөг зарцуулж, төсөвт 58.4 сая төгрөг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах талаар дараах ажил хийгдсэн байна. Үүнд:

2016 онд шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn –д эрх бүхий байгууллагаас баталсан 2016 оны төсвийн, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын болон бусад мэдээллүүдийг тухайн хугацаа бүрт оруулсан байна.

МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Байгууллагын үйл ажиллагааны онцлог болон нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг судлан, шинжилсний үндсэн дээр тус байгууллагын 2016 оны тайлант жилийн санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн “Санхүүгийн үр дүнгийн тайлан” дахь нийт зардлын дүнгийн 1% хувиар тооцож, 6.5 сая төгрөгөөр тогтоолоо.

ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу 3 эрсдлийг тогтоож батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс тус бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэсэний дүнд дараах асуудлууд илрэв. Үүнд:

- Байгууллагын ажилчдын цалинг бодох “Ажилласан цагийн бүртгэл” –ийг үнэн зөв, бодитой хөтөлдөггүй.
- Төсвийн захирагч ба нягтлан бодогч нарт батлагдсан дүнгээс 512.0 мянган төгрөгийн илүү урамшуулал олгосон.
- Өмч ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж буй байгууллагуудын түрээсийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүй.
- 2015 оны жилийн эцэст дутагдаж байсан 117.0 мянган төгрөгийн номны тооцоог бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчилтэй асуудлууд нь санхүүгийн тайлангийн хамааралтай байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байв. Эдгээр зөрчилтэй асуудлуудтай хамаарах олж тогтоосон эрсдэл, үр дагавруудын талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгаж, байгууллагын удирдлагад танилцуулсан.

ГОЛ, ОНЦЛОХ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага өглөг, үндсэн хөрөнгө, орлого, цалин хөлс, элэгдлийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн шалгалаа. /ТАБ-СТА-А-5-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 90 хувь, мөнгөн хөрөнгийн 95 хувь, нийт зардлын 90 хувь, нийт хөрөнгийн 50 хувийг тус тус эзэлж байна.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд эд ангиар нь салган үнэлж бүртгэх боломжтой 136.2 сая төгрөгийн орчуулгын систем, 111.0 сая төгрөгийн богино долгионы радио станц, 71.9 сая төгрөгийн DVD бичлэгийн систем, 54.2 сая төгрөгийн видео хурлын систем гэх мэт өндөр үнийн дүнтэй хөрөнгүүдийг иж бүрдлийн нийт үнийн дүнгээр хөрөнгө байдлаар бүртгэлд тусгасан.

Шийдвэрлэсэн: Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулсан.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

2. 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 4.3 сая төгрөгийн өртөг бүхий ном, 0.2 сая төгрөгийн өртөг бүхий тавилга, эд хогшил дутагдсан зөрчил илэрсэн. Үүний мөрөөр бүртгэлд давхардаж бүртгэгдсэн болон дутагдсан нийт 4.2 сая төгрөгийн ном, 0.2 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг актлах шийдвэр гарсан. Харин 0.1 сая төгрөгийн дутагдсан номыг бүртгэлд зохих ёсоор бүтгээгүй байна.

Шийдвэрлэсэн: Дутагдсан шалтгааныг тодорхойлж асуудлыг шийдвэрлэсэн.

3. Тус байгууллагын эзэмшлийн байранд нийт 5 байгууллага, төслийн нэгж, үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс “Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа” болон “Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь”, “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ төсөл” –үүд 260,000 - 300,000 төгрөгийн түрээсийн төлбөрийг сар бүр төлөхөөр өмч ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр гэрээний дагуу үнэ төлбөргүйгээр нийт 1,080,000 төгрөгийн бараа материал хүлээн авч орлогоор бүртгэсэн боловч төлөгдөөгүй 5,640,000 төгрөгийн түрээсийн авлагыг бүртгэлд аккрузл сууриар тусгаагүй байна

Шийдвэрлэсэн: Жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулсан.

4. Тус байгууллага 2016 оны 11 дүгээр сарын 01 –ний өдрөөс эхлэн ажилчдын цагийн бүртгэлийг хурууны хээ уншигч автомат машинаар бүртгэж эхэлсэн. Ажилчдын ажилласан цагийг мөн харуулын бүртгэлээр хөтөлдөг. Энэхүү хоёр мэдээллийг байгууллагын хүний нөөц нэгтгэж, нягтлан бодогчид өгдөг

байна. Эдээр 3 өөр эх үүсвэрээр бүртгэгдсэн ажилчдын ажилласан цагийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

5. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны 06 дугаар сарын 10 –ны өдрийн А/191 дугаар тушаалаар харъяа төсвийн байгууллагуудад 2015 оны санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт авсны урамшуулал олгохоор шийдвэрлэсний дагуу тус байгууллагын захирлын гаргасан 2016 оны 08 дугаар сарын 10 –ны өдрийн А/28 дугаар тушаалд төсвийн захирагч ба нягтлан бодогчид нийт 2.2 сая төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн байтал 2.7 сая төгрөг олгож, батлагдсан дүнгээс 0.5 сая төгрөгийн илүү олголт хийжээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. –д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг мөн тус байгууллагын захирлын 2016 оны 08 дугаар сарын 10 –ны өдрийн А/28 дугаар тушаалыг тус тус зөрчжээ.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй үлдсэн бусад алдаа байхгүй.

АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалалах төвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 381.0 сая төгрөгийн асуудал илрүүлж, асуудал тус бүрт зөвлөмж өгөв.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Төсвийн шууд захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Үндэсний аудитын газар” –аас өгсөн 4 зөвлөмжийг өгснөөс 3 –ийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан. Хэрэгжүүлээгүй үлдсэн зөрчлийн хувьд давхардуулан бүртгэсэн номнуудыг бүртгэлээс хасуулахаар холбогдох дээд байгууллагад бичгээр хүсэлт гаргасан бөгөөд 2016 онд жагсаалтыг шинэчлэн дахин хүсэлт гаргасан байна.

ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалалах төвийн 2016 оны 12 дугаар сарын 31 – ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад тус байгууллагын уг өдрөөрх санхүүгийн байдал хийгээд уг өдрөөр тасалбар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, заавар журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

.



ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:

Үндэсний Аудитын Газрын -
Санхүүгийн Аудитын Газрын

Дарга: Ц.Наранчимэг
Утас: 263533

Аудитын менежер : Я.Самбууням
Утас: 260512

Аудитор: Ж.Болормаа

“Координат Аудит” ХХК –ийн
Гүйцэтгэх захирал : П.Баярмаа
Утас: 99193732

Монгол Улсын Үндэсний Аудитын
Газар

Хаяг :Засгийн газрын IV байр,
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу – 6,
Улаанбаатар – 46, Монгол улс

Вэб хуудас : www.mnao.pmis.gov.mn

Хэвлэсэн огноо :
2017 оны 02 –р сарын 13

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

2016 оны Санхүүгийн тайлангийн аудит

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн
талаар

Асуудал 2 Үйл ажиллагааны орлого ба
дансны авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 3 Үйл ажиллагааны зардал ба
тушаал шийдвэрийн талаар

Асуудал 4 Цалингийн тооцоолол,
тайлагналын талаар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” –ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Энэ нь “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” –ийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тэргүүлэх ач холбогдол №1: Цаашид санхүүгийн тайланд (энэ оных биш) шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул нэн даруй анхаарвал зохих асуудлууд;

Тэргүүлэх ач холбогдол №2: Удирдлагын анхаарах шаардлагатай асуудлууд; ба

Тэргүүлэх ач холбогдол №3: Аудитын явцад бидний ажигласан бөгөөд цаашид аудитын санал дүгнэлтэд нөлөөлөх магадлалгүй асуудлууд.

Асуудал 1 Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
<u>Ажиглалт:</u> Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд иж бүрдэл бүхий 136,207,500 төгрөгийн үнэ бүхий Орчуулгын систем, 111,016,500 төгрөгийн Богино долгионы радио станц, 71,992,500 төгрөгийн DVD бичлэгийн систем, 54,246,000 төгрөгийн Видео хурлын систем гэх мэт өндөр үнийн дүнтэй хөрөнгүүдийг томоохон эд ангиар нь салгаж бүртгэлгүй дан ганц хөрөнгө байдлаар бүртгэлд тусгасан.	<u>Зөвлөмж:</u> УСНББОУС 17 – Үндсэн хөрөнгө –ийн 59 – д “Үндсэн хөрөнгийн зүйлийн хэсэг тус бүрийн өртөг нь тухайн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц хэмжээтэй байвал тусад нь элэгдүүлнэ” гэсний дагуу багц хөрөнгүүдийг иж бүрдэл тус бүрээр нь салгаж бүртгэлд тусгах.
<u>Эрсдэлүүд:</u> Байгууллагын үндсэн хөрөнгийн захиран зарцуулалт, түүнд тавигдах хяналт алдагдах.	<u>Төсвийн шууд захирагчийн хариу:</u> Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу жилийн эцсийн тайланд хөрөнгийг салгаж бүртгэсэн.

Асуудал 2: Үйл ажиллагааны орлого ба дансны авлагын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
<u>Ажиглалт:</u> Тус байгууллагын эзэмшлийн байранд нийт 5 байгууллага, төслийн нэгж, үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс “Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа” болон “Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь”, “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ төсөл” –үүд 260,000 - 300,000 төгрөгийн түрээсийн төлбөрийг сар бүр төлөхөөр өмч ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр гэрээний дагуу үнэ төлбөргүйгээр нийт 1,080,000 төгрөгийн бараа материал хүлээн авч орлогоор бүртгэсэн боловч төлөгдөөгүй 5,640,000 төгрөгийн түрээсийн авлагыг бүртгэлд тусгаагүй байна.	<u>Зөвлөмж:</u> Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” –нд Төсвийн байгууллага нь УСНББОУС –ыг мөрдөхөөр заасан ба Төсвийн тухай хуулийн 26.1-д төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлнө гэж заасныг мөрдөх. УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандартаар Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулахыг шаарддаг.
<u>Эрсдэлүүд:</u> Байгууллагын санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлын тайлан алдаатай тайлагнагдах. Орлогыг дутуу цуглуулах эрсдэлтэй.	<u>Төсвийн шүүд захирагчийн хариу:</u> Завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу алдааг жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулан бүртгэсэн.

Асуудал 3: Үйл ажиллагааны зардал ба тушаал шийдвэрийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>Ажиглалт</u> Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны 06 дугаар сарын 10 –ны өдрийн А/191 дугаар тушаалаар харъяа төсвийн байгууллагуудад 2015 оны санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт авсны урамшуулал олгохоор шийдвэрлэсний дагуу тус байгууллагын захирлын гаргасан 2016 оны 08 дугаар сарын 10 –ны өдрийн А/28 дугаар тушаалд төсвийн захирагч ба нягтлан бодогчид нийт 2,220,150 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн байтал 2,732,285 төгрөг олгож, батлагдсан дүнгээс 512,135 төгрөгийн илүү олголт хийжээ.	<u>Зөвлөмж</u> Төсвийн захирагч нь "Төсвийн тухай хууль" -ийн 6.4.8. -д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэснийг мөрдөж, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг мөрдлөг болгох.
<u>Эрсдэлүүд</u> Төсвийн орлогыг үр ашиггүй зарцуулах.	<u>Төсвийн шууд захирагчийн хариу</u> Олгосон урамшуулал захирлын тушаалаар батлагдсан дүнгээс 512,135 төгрөгөөр хэтэрч байгаа боловч Санхүү эдийн засгийн сайдын 2002 оны 07 дугаар сарын 25 –ны өдрийн “Санхүү бүртгэлийн ажилтнуудад тэдний үйл ажиллагааны үр дүнг үндэслэн шагнал, урамшуулал олгох тухай журам” –ын 2.3 –т заасан дүнгээс хэтрэхгүй байна.

Асуудал 4 Цалингийн тооцоолол, тайлагналын талаар	Тэргүүлэх ач холбогдол №3
<u>Ажиглалт</u> Тус байгууллага 2016 оны 11 дүгээр сарын 01 –ний өдрөөс эхлэн ажилчдын цагийн бүртгэлийг хурууны хээ уншигч автомат машинаар бүртгэж эхэлсэн. Ажилчдын ажилласан цагийг мөн харуулын бүртгэлээр хөтөлдөг. Эдгээр бүртгэлийн мэдээллийг байгууллагын хүний нөөцийн ажилтан нэгтгэж, ажлын цагийн баланс бэлтгэн нягтлан бодогчид өгдөг байна. Дээрх 3 төрлийн /эх үүсвэрээр/ бүртгэгдсэн ажлын цагийн бүртгэл тодорхой шалтгаан, логик холбоогүйгээр хоорондоо зөрүүтэй байдаг байна.	<u>Зөвлөмж</u> Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1 –д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” гэж заасны дагуу ажилчдын цагийн бүртгэлийг үнэн зөв хөтлөх.
<u>Эрсдэлүүд</u> Цалингийн тооцоо буруу бодогдох. Мөн ажлын үр дүнг тооцох, хянах тогтолцоо алдагдана.	<u>Төсвийн шүүд захирагчийн хариу</u> Цаашид ажлын цаг ашиглалтын журам боловсруулан бүх ажилтан албан хаагчдад мөрдүүлнэ.

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ

2016 оны 12 -р сарын 31 –ээр тасалбар болсон тайлант жилийн

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	2015/12/31 -ний үлдэгдэл	2016/12/31 -ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
3101	Кассанд байгаа бэлэн мөнгө	19,023	10,000
		19,023	10,000
33	АВЛАГА		
3305	Бусад авлага	5,219,899	35,797,500
		5,219,899	35,797,500
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР		
35	БАРАА МАТЕРИАЛ		
3501	Аж ахуйн материал	57,826,547	53,349,990
3503	Бусад хангамжийн материал	9,451,863	9,835,994
		67,278,410	63,185,984
36	НӨӨЦИЙН БАРАА		
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,517,331	98,993,484
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
3901	ГАЗАР	0	0
3902	БИЕТ ХӨРӨНГӨ		
39020101	Барилга, байгууламж	7,191,400,841	7,191,400,841
39020102	Хуримтлагдсан элэгдэл	(224,745,174)	(348,608,194)
39020301	Машин, тоног төхөөрөмж	1,738,251,190	1,738,675,190
39020302	Хуримтлагдсан элэгдэл	(893,853,432)	(1,241,327,270)
39020401	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,754,840	243,754,840
39020402	Хуримтлагдсан элэгдэл	(61,229,273)	(88,875,221)
390207	Түүх соёлын дурсгалт зүйлс	53,811,100	56,433,400
39020803	Номын фонд	13,090,600	13,090,600
		8,060,480,692	7,564,544,186
3903	БИЕТ БУС ХӨРӨНГӨ		
39030101	Програм хангамж	1,675,000	1,675,000
39030102	Хуримтлагдсан элэгдэл	(939,458)	(1,430,750)
		735,542	244,250
38	БУСАД ХӨРӨНГӨ		
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,061,216,234	7,564,788,435
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,133,733,565	7,663,781,919
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ			
510301	Өмнөх үеийн үр дүн	8,133,733,565	8,133,733,565
510302	Тайлант үеийн үр дүн	0	(469,951,646)
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	8,133,733,565	7,663,781,919
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	8,133,733,565	7,663,781,919

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ

2016 оны 12 -р сарын 31 –ээр тасалбар болсон тайлант жилийн

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	323,390,203	414,983,200
130301	Улсын төсвөөс	312,992,690	293,776,700
13030101	Урсгал	312,992,690	293,776,700
13030114	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,397,513	121,206,500
1303011401	Төрийн болон ор.нут.өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	0	121,206,500
1303011406	Төсвийн урамшуулал	10,397,513	0
14	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	12,790,306	22,043,236
140201	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	12,790,306	22,043,236
14020101	Үндсэн үйл ажиллагааны орлого	6,640,000	14,420,000
14020102	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	0	6,720,306
14020105	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,150,306	902,930
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	336,180,509	437,026,436
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,791,874	881,939,279
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	245,878,574	224,529,656
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	221,463,437	202,238,956
210101	Цалин	212,800,637	184,913,956
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,662,800	17,325,000
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	24,415,137	22,290,700
	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	20,129,148	18,237,800
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	15,690,744	14,184,900
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,793,229	1,621,200
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,216,574	2,026,400
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	428,600	405,300
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,285,989	4,052,900
2103	Тогтмол зардал	23,749,356	28,808,309
210301	Гэрэл цахилгааны зардал	12,650,325	14,127,772
210302	Түлш, халаалтын зардал	7,252,078	10,634,875
210303	Цэвэр, бохир усны зардал	3,846,953	4,045,662
2104	Хангамж, бараа материалын зардал	13,998,220	24,239,892
210401	Бичиг хэргийн материал	2,135,710	7,652,979
210402	Тээвэр, шатахууны зардал	4,015,276	5,749,124
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	5,203,140	3,298,091
210404	Ном, хэвлэлийн зардал	233,200	0
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,410,894	2,448,147
210408	Бараа материал актасны зардал	0	5,091,551
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	772,942	572,040
210604	Урсгал засвар	772,942	572,040
2107	Томилолт, зочны зардал	669,500	25,382,000
210702	Дотоод томилолтын зардал	669,500	25,382,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,657,423	5,725,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил.үйлч-ий төл.хураамж	5,222,173	5,375,000
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	350,000	350,000
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	74,250	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,000	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	418,065,858	572,682,382
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	11,374,023
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	11,770,107	61,834,260
22010322	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	406,295,751	499,474,099
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,246,547	25,038,803
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,246,547	25,038,803
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,908,259	0
213206	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,338,288	25,038,803
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,153,290	0
223001	Бусад хөрөнгө	1,153,290	0

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	746,191,711	906,978,082
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(410,011,202)	(469,951,646)

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ

2016 оны 12 -р сарын 31 –ээр тасалбар болсон тайлант жилийн

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2014 оны 12 -р сарын 31-ээрх үлдэгдэл	0	8,543,744,767	8,543,744,767
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	8,543,744,767	8,543,744,767
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	(410,011,201)	(410,011,201)
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0	8,133,733,565	8,133,733,565
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	8,133,733,565	8,133,733,565
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0
Тайлант үеийн үр дүн	0	(469,951,646)	(469,951,646)
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0	7,663,781,919	7,663,781,919

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ

2016 оны 12 -р сарын 31 –ээр тасалбар болсон тайлант жилийн

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	323,390,203	414,983,200
130301	Улсын төсвөөс	312,992,690	293,776,700
13030101	Урсгал	312,992,690	293,776,700
13030114	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,397,513	121,206,500
1303011401	Төрийн болон ор.нут.өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	0	121,206,500
1303011406	Төсвийн урамшуулал	10,397,513	0
14	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	6,640,000	14,420,000
1402	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	6,640,000	14,420,000
14020101	Үндсэн үйл ажиллагааны орлого	6,640,000	14,420,000
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	330,030,203	429,403,200
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,375,166	370,987,920
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	245,883,018	224,523,181
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	221,571,541	202,232,481
210101	Цалин	204,246,541	184,907,481
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,325,000	17,325,000
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	24,311,477	22,290,700
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	15,470,940	14,184,900
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,768,107	1,621,200
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,210,134	2,026,400
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	442,027	405,300
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,420,269	4,052,900
	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	45,492,148	146,464,738
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	18,921,074	28,808,309
210301	Гэрэл цахилгааны зардал	12,650,325	14,127,772
210302	Түлш, халаалтын зардал	2,423,796	10,634,875
210303	Цэвэр, бохир усны зардал	3,846,953	4,045,662
2104	Хангамж, бараа материалын зардал	11,883,938	15,339,046
210401	Бичиг хэргийн материал	1,923,350	5,380,160
210402	Тээвэр, шатахууны зардал	4,194,400	5,570,000
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	2,335,140	3,298,091
210404	Ном, хэвлэлийн зардал	1,368,150	
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,062,898	1,090,795
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,106	402,100
210604	Урсгал засвар	1,300,106	402,100
2107	Томилолт, зочны зардал	669,500	25,382,000
210702	Дотоод томилолтын зардал	669,500	25,382,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,878,050	5,725,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,442,800	5,375,000
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	350,000	350,000
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	74,250	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,000	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,839,480	70,808,283
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		6,874,023
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	7,839,480	63,934,260
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,246,547	58,424,303
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,246,547	58,424,303
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,908,259	
213208	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,338,288	58,424,303
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	327,621,713	429,412,223
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,408,490	(9,023)
223001	Бусад хөрөнгө	2,409,290	0
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,409,290	0
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,409,290)	0

НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

(800)

(9,023)

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл

19,823

19,023

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл

19,023

10,000

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ

2016 оны 12 -р сарын 31 –ээр тасалбар болсон тайлант жилийн

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)				
ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
I. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		19,023	(19,023)	-
II. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (III+IV+V+VI)	387,070,200	370,978,897	16,091,303	95.8
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	387,070,200	370,978,897	16,091,303	95.8
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,417,700	370,978,897	15,438,803	96.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	202,641,700	202,232,481	409,219	99.8
Үндсэн цалин	185,316,700	184,907,481	409,219	99.8
Унаа хоолны хөнгөлөлт	17,325,000	17,325,000	0	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,290,700	22,290,700	0	100.0
Тэтгэврийн даатгал	14,184,900	14,184,900	0	100.0
Тэтгэмжийн даатгал	1,621,200	1,621,200	0	100.0
ҮОМШӨ-ний даатгал	2,026,400	2,026,400	0	100.0
Ажилгүйдлийн даатгал	405,300	405,300	0	100.0
Байгууллага төлөх ЭМД-ийн хураамж	4,052,900	4,052,900	0	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,668,100	28,808,309	13,859,791	67.5
Гэрэл цахилгааны зардал	18,048,100	14,127,772	3,920,328	78.3
Түлш халаалтын зардал	20,100,000	10,634,875	9,465,125	52.9
Цэвэр, бохир усны зардал	4,520,000	4,045,662	474,338	89.5
Хангамж, бараа материалын зардал	15,339,500	15,339,046	454	100.0
Бичиг хэргийн материал	5,710,000	5,380,160	329,840	94.2
Тээвэр шатахууны зардал	5,570,000	5,570,000	0	100.0
Шуудан холбооны зардал	2,921,000	3,298,091	(377,091)	112.9
Бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс	1,138,500	1,090,795	47,705	95.8
Эд хогшил худалдан авах	592,300	402,100	190,200	67.9
Урсгал засвар	592,300	402,100	190,200	67.9
Томилолт, зочны зардал	26,086,100	25,382,000	704,100	97.3
Дотоод томилолтын зардал	26,086,100	25,382,000	704,100	97.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	6,000,000	5,725,000	275,000	95.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,400,000	5,375,000	25,000	99.5
Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс	350,000	350,000	0	100.0
Даатгалын үйлчилгээ	120,000	0	120,000	-
Тээврийн хэрэгслийн татвар	70,000	0	70,000	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	60,000	0	60,000	-
Бараа үйлчилгээний бусад зардал	70,799,300	70,799,260	40	100.0
Бараа үйлчилгээний бусад татвар	6,865,000	6,865,000	0	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,934,300	63,934,260	40	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	625,500	0	625,500	-
Бусад урсгал шилжүүлэг	625,500	0	625,500	-
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	652,500	0	652,500	-
IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0	0	-
V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	0	0	-
VI. ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0	0	0	-
VII. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	387,070,200	370,978,897	16,091,303	95.8
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилт	0	4,820,000	(4,820,000)	-
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих –нэмэлт санхүүжилт	92,641,000.00	87,821,000	4,820,000	94.8
Улсын төсвөөс санхүүжих	294,429,200	278,337,897	16,091,303	94.5
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл		10,000	(10,000)	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт				-
Байгууллагын тоо		1	1	-
Ажиллагсдын тоо	25	25		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	18	18		
Үйлчлэх ажилтан	6	6		